

ТҮШЭЭТ ХАН ЧАХУНДОРЖИЙН НИЙГЭМ, УЛС ТӨРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУХАЙД

Г.Сэр-Од

“Их Монгол” дээд сургууль.

Өгүүллийн товч утга: Түшээт хан Чахундоржийн нийгэм, улс төрийн үйл ажиллагааг дахин эргэцүүлэн шинжилж, түүний түүхэнд эзлэх байр суурийг үнэн зөвөөр тайлбарлахад оршино.

Түлхүүр үг: Улс төрийн бутрал, самуун цаг, Халх-Ойрадын дайн, Олгой нуурын тулалдаан, Халх, Ойрад, Манж, Долоннуурын чуулган.

Монгол орон ардчилсан улс төрийн уур амьсгалаар амьсгалж, түүний үр дүнд тус орны нийгэм, улс төр эдийн засаг соёл шинжлэх ухааны салбаруудад шинэ өнгө аяс гүнзгий нэвтэрч ирэв.

Өнгөрсөн үед бид түүхт хүмүүс, түүхэн зүтгэлтнүүдийн намтар үйл ажиллагааг судлан боловсруулах ажил хоцронгуй явж, тэдний үйл ажиллагааг зөвхөн нэг талаас нь харж, өрөөсгөлөөр дүгнэдэг алдаатай байр суурь баримталж байсан бөлгөө. Тэр ч бүү хэл түүхт хүмүүс, түүхэн зүтгэлтнүүдийн гүйцэтгэсэн үүргийг дутуу үнэлэх, цаг хугацааны аясаар үйл ажиллагааг нь орхигдуулах, гуйвуулах, түүхийг эзэнгүйдүүлэх бурангуй ёсон монголын түүх бичлэгт байр сууриа удаан хугацаанд хадгалсаар байсан амой.

Түшээт хан Чахундоржийн амьдарч байсан ХҮИ зууны сүүлийн хагас бол Монгол ноёдууд олон зууны турш үргэлжилсэн улс төрийн бутралын оргил үе, түүнийг даван туулахын төлөө цохилох зүрхний эцсийн лугшил чинээндээ тулж, Монгол гүрний улс төрийн бодлого эрс хурцадсан түүхэн чухал эгзэгтэй үе бөлгөө.

Түшээт хан Чахундорж бол орь залуу хориодхон насандаа Халхын ихэнх хүчийг эрхшээн мэдэж, нийгэм улс төрийн үйл ажиллагаанд оролцож эхэлсэн болой. Тэрбээр тухайн үедээ хамгийн залуугаараа ханы суудалд сууж, Монгол болон төв Азийн улс төрийн харилцаанд чухал үүрэг гүйцэтгэж явсан улс төрийн томоохон зүтгэлтэн байв.

Түшээт хан Чахундорж 1655–1697 онд Халх Монголын төрийн эрхийг дүү анхдугаар богд Жибзундамба хутагтын номын хүчинд тулгуурлан голлон эрхшээж, халх монголыг зэвсгийн хүчээр нэгтгэхийг хичээж цагийг элээж, оюунаа сааж, ард иргэд харьяат олноо тухайн орон зай цаг хугацаанд хамгийн хөнөөл хохирол багатай замаар замчилж чадсан түүхэнд “самуун цагийн сайн хаан” хэмээн алдаршсан нэгэн билээ.

Өдгөө бид сайхь хүмүүний нийгэм улс төрийн үйл ажиллагааны тухай өгүүлэхдээ юуны өмнө түүний угсаа гарлын талаар авч дурьдах нь зүйтэй болов уу хэмээсэнээс гадна Халхын ноёдтой хямралдан улмаар Халх, Ойрад хоёрын хооронд дайтах болсон түүхэн үйл явц хийгээд Манж дайчин гүрнээс төр шашны тусламж эрэн дагах болсон зэрэг асуудлыг тоймлон авч үзье.

Намтрын өлгөц: ХҮИ зууны Монголын түүхэнд баларшгүй мөрөө үлдээсэн Очирай бат тулгар Түшээт хан Гомбодоржийн Чахундорж нь дурьдаж буй үеийн халхын нөлөө бүхий гурван ханы нэгэн болох “Очирай хаан сайн” цолыг хоёрдахь удаагаа залгамжлагч Эрээхэйн Гомбодоржийн гэрт хүй тасарч, хүмүүн заяа залгажухуй.

Түүхийн сурвалж бичиг судалгааны бүтээлүүдэд, сайхь хүмүүнийг 1699 онд нөхчив /1/ хэмээн нас эцэслэсэн оныг нь бичсэн байдгаас бус чухам хэдийд төрсөн болохыг магадлах баримт одоогоор бидэнд олдоогүй байна. Харин бид энэ дашрамд уг асуудалд нэгэн таамаглал дэвшүүлэхийг

зорьсон юм. Юу хэмээвээс Түшээт хан Чахундоржийн насыг барагцаалан тогтоох гэсэн оролдлого болой. Дурьдан буй үеийн Монголчуудын ах дүүсийн насны зөрүүг гурваас тав байсан хэмээн үзвээс, хан Чахундорж 1630 – 1632 оны хооронд төрсөн байж болзошгүй юм. Учир нь сайхь ханы төрсөн дүү болох өндөр гэгээн Занабазар 11 дүгээр жарны модон гахай жил буюу 1635 онд төрсөн хэмээн эрдэмтэд үздэг. Өндөр гэгээний төрсөн он /1635/ дээр тулгуурлан өмнө дурьдсан таамаглалаар хан Чахундоржийн төрсөн оныг 1632-1633 оны орчим хэмээн үзсэн бидний эрэлхийлэл нь түүхэн баримт сэлтээр хомс ч гэлээ ямар боловч энэ их хүмүүний үйл ажиллагааг цааш нь үргэлжлүүлэн судлах явцад түүний төрсөн он цагийг тогтоох явдал чухлаар тавигдаж байгаа юм.

Чахундорж хан нь эцгийн талаараа боржигин овогт хиад яст бөгөөд эхийн талаараа дөрвөд аймгийн хошууд овогтой байлаа. Халхын дөрвөн аймгийн ноёдын төрснийг тоолбоос “Чингис хэмээх Тайзу хаан, ... түүний арвангуравдугаар үеийн ач Батмөнх даян сэцэн хаан түүний арваннэгдүгээр хөвгүүн Гэрсэнз жалайр хунтайж долдугаар хөвгүүнээс өсөн дэлгэрсэн халхын дөрвөн аймгийн хан, ван, бэйл, бэйс, гүн засаг болон тайж нар эд цөм боржигин овогт хиад яст амой” /2/ хэмээн эцгийн талын өвөг дээдсийг түүх шастирт тэмдэглэжээ. Түшээт хан Чахундорж нарын элбэрэлт эх, хан эцгийн халамжит хатан нь Ойрад дөрвөдийн Далай тайжийн охин, харваас өнгө дүрс үзэсгэлэнтэй, их хотын эрдэнэ адил ааль усгал номхон доторхи сэтгэл шулуун шударга лам гурван эрдэнэд сүсэг төгөлдөр, зүстэй сайхан хатан ёстой сайн ээж болох Ханджамц болой.

Ханджамц хатны өвөг дээдсийг тогтоохын тулд түүний эцэг Очирт сэцэн хаанаас эхлэн түүний өвөг дээдсийг хайвал илүү үр дүнтэй. Язгуурын монголчуудын дээд өвөг Бөртэ чоно бөлгөө. Түүний хөвгүүн Батцагаан. Батцагаан /Батичи хан/-ны хөвгүүн Дэмчиг түүний хөвгүүн Хоричар мэргэн түүний Уужим буурал түүний хүү Сальхачу, түүний хүү Нэг нүдэн /Их нүдэн Г.С/ түүний хөвгүүн Сэмсочи /Шимсочи/, түүний хүү Галирарчун, түүний хүү Боржигидай мэргэн түүний хүү Хорогчин /Торголжин Г.С/ баян, түүний хүү Борогчин гоо хатнаас төрсөн Дуба сохор, Добу мэргэн болой” /3/ хэмээжээ.

Дуба сохорын наймдугаар үеийн ач Бору Ногул Дөрвөдийн ноёдын уг эх, арван дөрөвдүгээр үеийн ач Баатар хунтайж Өөлдийн ноёдын уг эх болсон төдийгүй Добу мэргэний арван нэгдүгээр үеийн ач Чингис хаанаас боржигин овогт хиад яст хаад ноёд үүсвэрлэж, түүний арван тавдугаар үеийн ач Гэрсэнз халхын ноёд хаад үе залгамжилсан бөлгөө. Ойрадын ноёдын дээд овог болох Дуба сохорын долдугаар үеийн ач Эсэн хаан болой. Түүний хөвгүүн Бору Ногул, Эрмүн Дархан ноён хоёр болой. Эсэн хааны бага хүү Эсмүн дархан тайжаас угшилтай долдугаар үеийн ач Баатар хунтайж, харин Бору Ногулын тавдугаар үеийн ач нь Ханджамц охин болж цохилдож байна/4/ хэмээсний Баатар хунтайж нь Ойрадын Галдан хааны эцэг харин Ханджамц охин хэмээгч нь Чахундоржийн хатан эх болно. Чингэвэл, хан Чахундорж, өндөр гэгээн Занабазар ба Ойрадын Галдан хаан нар нь ураг төрлийн цусан холбоотой, ясан барилдлагаатай болох нь тогтоогдож байна.

Эвийн өлзий утас лугаа сүлжилдсэн ураг төрлийн холбоо тэднийг ямар учраас хурдан хүлгийн том дөрвөн туурай халх монголыг талхлуулж, хурц илдний цагаан ааг эрхи зүүсэн хуврагын хүзүү эрдэнэ титэмлэсэн бурхадын тэргүүн хоёрт ээлжлэн буусаар сэлэм жадны хангинах дуунд энх амгалангийн агаар байгаль эхийн хормойнд бууж ураг төрлийн холбоо салхинд үлээгдсэн талд бутран унах болов. Энэ бол цагийн хүлээц түүхийн нууц амой.

Халхын ноёдын хямралдаан ба Халх Ойрадын дайн. ХҮП зууны эхэн үед феодалын бутралын улмаас Монголын эзэнт гүрний эзэмшил Ар, Өвөр,

баруун хэмээн хуваагдсан. Чингис хааны байгуулсан их гүрний хойчийг залгамжлагч хаадын үрс бие биетэйгээ эвийг үл сахин илдийг харшилдуулан язгууртны ёсны мөхлийн хар хонхны оосроос татаж, хон хэрээний зоогонд биенээ яахин түлхнэм.

Зарим эрдэмтдийн тэмдэглэсэнчлэн, Халхын тусгаар тогтнолыг хамгаалахын төлөө цогтой тэмцэхээр элдвээр оролдож байсан Түшээт хан Гомбодорж, өвгөн сэцэн хан Шолой нар 1655 онд нас барсан явдал, мөнхүү баруун гарын засагт ханы ширээнд залуу хан суусан зэрэг үйл явдлууд нь Халхын нийгэм, улс төрийн амьдралд хүчтэй нөлөөлөөд зогсохгүй хөрш зэргэлдээ улсуудынхаа улс төр, эдийн засгийн сонирхолын шуналыг хөдөлгөсөн юм. Чингэтэл шинэ Түшээт хан Чахундорж Халх-Ойрадын нийтийн чармайлтыг нэгтгэхэд чиглэсэн 1640 оны чуулганы шийдвэрийг зөрчиж, Халхын баруун, зүүн гарын хооронд нөхөрсөг харилцахын оронд дайсагнах бодлого явуулж эхэлсэн байна /5/ хэмээн дурьдсаныг үзэхүл түүхэн утга учрын нарийн ээдрээтэй, зангилаа асуудлыг сайтар шинжлэн үзэлгүй хөнгөн хуумгай хандсан хэрэг.

Дурьдан буй үед Халхад Түшээт хан, Засагт хан, Сэцэн хан нараас дутахааргүй өөрийн гэсэн хаанчлалыг тогтоогоод байсан Монголын их соён гэгээрүүлэгч Г.Занабазар Монголчуудын оюун санааг номын хүчээр байлдан дагуулж, нэгтгэн бүлгэмдүүлэхийг оролдож байлаа. Занабазар Халхын шашны тэргүүн хутагт мөний хувьд хүссэн ч хүсээгүй Монголын нийгэм-улс төрийн нарийн төвөгтэй амьдралын эргүүлгэнд татагдан орсон. Тиймээс тэрээр Халхын ноёдын тэр тусмаа өөрийн ах түшээт хан Чахундоржийн баримталж байсан гадаад бодлого ялангуяа идэвхитэй харилцагч Түвэд болон Манж чин улстай харилцах харилцаанд нилээд өндөр байр суурьтай дотны зөвлөгч, хамтран зүтгэгч нь байлаа. Чухам энэ л үед засагт хан Норов нас барж, түүний орыг залгахын төлөө зөрчил тэмцэл хүчтэй дэгдэж эхлэв. Мөн энэ улс төрийн хямрал нь нийт Монгол үндэстний эв нэгдлийн хүчийг цалгардуулж, энэ мэт тулга тойрсон нутгийн зөрчилдөөн нь эцэстээ нийт Монголчуудын тусгаар тогтнолд 153 жил чөдөр тушаа болж ирсэн бөлгөө. Үүний нэг гол шалтгаан бол 1662-1697 оны Халх, Ойрадын дайн болой.

ХҮИ зууны эхэн үед феодалын бутралын улмаас Монголын эзэнт гүрний эзэмшил Ар, Өвөр, Баруун хэмээн хуваагдсан. Чингис хааны байгуулсан их гүрний хойчийг залгамжлагч хаадын үрс бие биетэйгээ эвийг үл сахин илдийг харшилдуулан язгууртны ёсны мөхлийн хар хонхны оосроос татаж, хон хэрээний зоогонд биенээ яахин түлхнэм.

Засагт ханы “*өндөр сэнтий*”-г булаалдсан ахан дүүсийн хэрэг явдал нь ширээний төлөөх тэмцэл нь аймаг доторх болон аймаг хоорондын самуурлаас хол хальтирч, олон улсын шинжтэй болон хувирав. Олон улсын хэмээдэг учир нь элэг нэгт эзэрхэг, түрэмгий Зүүнгарын хаант улс, тухайн цаг үеийн нийт Монгол орныг номын бодлогоор тольдон гийгүүлэгч Түвэд орон, цагийн аяс, сэтгэлийн байцыг танадагч Манж гүрэн оролцох болсон явдал болно.

Манжийн эзэн хаан Халх дотоодын самууныг дарсны дараагаар халхын хэрэг явдалд тууштай оролцож, Халхын баруун, зүүн гарыг эвлэрүүлэн нийлүүлэхдээ Түвэдийн Далай ламын номын хүчинд машид итгэн байв. Энх-Амгалан хаан, Түвэдийн Далай ламд илгээсэн зарлигийн бичигт “Би дэлхий дахиныг нэгтгэн засахын тулд дотоод гадаадыг дайлах зүдгүүргүй салах сарних гашуунгүй болгож олон амьтдыг цөм энх амгалан жаргуулах үед хүргүүлсүгэй хэмээмой. Бид элч зарж, Засагт ханы салсан албадыг эргүүлэн өгүүлж хоёр агар/ түшээт хан Чахундорж, Зүүнгарын Галдан бошгот хаан/-ыг үүрд найрамдалтай болгох уулзах явдлын өдөр сарыг тогтоон болзож илгээгтүн. Би эндээс элч гаргаж болзсон газарт ламын элчийн хамт нийлж очтугай хэмээн “ /6/ бичсэнийг үзэхүл, Түшээт ханыг дэмжин, Галдан бошготыг

ганцаардуулж Халхын ноёдыг хооронд нь хямралдуулан тэмцэлдүүлж хагалах бодлого барьж халхыг гадаад ертөнцөөс тусгаарлаж бин битүү байлгахад чухал байр суурь эзэлсэн /7/ хэмээн үзэмгүй байна.

Хэрэв манжийн эзэн хаан Энх-Амгалан дээр өгүүлсэнчлэн харгис дарангуй бодлого баримталж байсан бол Түшээт хан Чахундоржийг цэрэг гуйхад эс зөвшөөрснөөр үл барам дайтахыг зогсоож, хоорондоо эвтэй байхыг гуйж байхгүйсэн.

1682 оны билигийн улиралын хоёдугаар сарын 25 –ны өдөр V Далай лам 68 насандаа Бодала жанч халснаар Див Санжайжамц болон Хошуудын ханы далд тэмцэл явагдаж байсан учир нирваан болсон V Далай ламын учрыг гадагш өчүүхэн ч задруулалгүй арга хэмжээ тогтоож чадсан юм . Энэ мэтээр дэсрэд Санжайжамц Y Далай ламын хуурмаг нэрээр аливаа хуурмаг үйл ажиллагаа явуулахдаа Халхыг Манжийн болон Зүүн гарын хоорондын хэрүүлийн алим болгоход Халх, Ойрадын дайныг хурцатгаж, Түвэдээс Манжийн анхаарлыг холдуулах цаг хожин Галдан бошготыг Манжийн эсрэг босгоод өөрөө ард нь сэм үлдэх тактик хэрэглэсэн / 8/ нь нудраад авъя гэдэгчилэн хүчин мөхөсдөөд ирэхээр нь манжийн аманд бэлэн зууш болгохыг хүсэж байсан ч энэ нь бүтээгүй .

Түүх шастирыг үзэхүл, Халхын баруун, зүүн гарын Засагт хан, Түшээт хан аймгийн ах дүү албат иргэдийн хэрэг явдлаас үүсвэрлэсэн Халх, Ойрадын дайн хэмээгчийг 1688 оноос бус харин халхын Засагт ханы ширээний төлөө тэмцэл эхэлсэн 1662 оноос авч үзэх нь чухал юм. Ийн үзэх болсон нь академич Нацагдорж " ...засагт хан, түшээт хан нарын зөрөлдөөн нь явсаар Галдан бошгот, Чахундорж нарын тэмцэл болон солигдож, сүүлд Галдан бошгот Энх-Амгалан хаан нарын тэмцэл болон хувирчээ /9/ .

Ойрад-Халх хоорондын дайны хамгийн шийдвэрлэх том тулаан бол << **Олгой нуур**>>-ын тулалдаан юм. Эсгий туургатаны задралыг улам гүнзгийрүүлсэн ХҮП зууны сүүлийн хагаст болсон олон дайн тулаан дотроос уг тулалдааныг эрдэмтэд өөр өөрсдийн судалгаандаа дашрамын байдлаар өнгөц дүгнэсэн байдаг.

Чухамдаа Олгой нуурын тулалдааны эх үүсвэр нь Ойрад Монголын захирагч Галдан хааны өшөө авалтын хилэнгээр үүсвэрлэж, баруун Монголчууд оролцсон, харин Халх Монголыг ерөнхийлэн мэдэж байсан өндөр гэгээн Занабазар түшээт хан Чахундорж нарын нэгэнт нөмөрсөн дайны сүүдрийг туулан гарахаас өөр замгүй болсоноос үүсвэрлэн, халх Монголчууд зарим хэсэг нь оролцсоноор уг дайны эхлэл тавигдсан юм.

Олгой нуурын тулааны нэгэн онцлог бол ах дүүгийн барилдлагат овгууд тэр дундаа Дөрвөд овгийн үр хойчис язгуурын Боржигон овогтоны эсрэг дайтсан цуст тулаан бөлгөө.

Өнөөгийн түүхийн шинжлэх ухаанд Олгой нуурын тулаан хэмээн ярих мөртлөө түүнийг чухам хаана байдагийг тодорхой заасан зүйл алга байна.

Судалгааны бүтээлүүдэд дурьдагдсанчлан, " ...Олгой нуур хэмээх газарт уг дайн тулаан болсон тухай тэмдэглэл буйг харгалзан Олгой нуур хэмээгч нуур, цөөрмийн дэргэд үү, эсвэл тийм нэртэй тал, хээр газар тэрхүү тулаан болсон уу гэдгийг нарийвчлан тогтоох чухалтай байна.

Халх Ойрадын дайн хийгээд "Олгой нуур" хэмээх газар нь орчин үеийн сэтгэгчидийн тодорхойлсончлон "Иргэний дайн"-ы олон шинж чанарыг агуулж байна. Тухайлбал: "Олгой нуур" хэмээх газрын тулалдаан нь Галдан халх Монголыг Манжид дагаар орохоос сэргийлж, түүнээс өмнө хүч хавсран түшиц газар болгон Манжийн эсрэг тэмцэхийг оролдож байсаны үргэжлэл хэмээн үзэх нь үндэслэл бага байгаа явдал бол: нэгд-сайхь хоёр хүний нэг нь доройтон бусад гадны үндэстний хүчний тухайлбал улс төрийн бодлогод автагдах нь

ихэсэж буй байдлыг угсаа нэгт баруун Монгол-Ойрадууд зүгээр хараад сууж байх нь улс төрийн зохимжгүйдэл байсан; **хоёрт**-хоёр этгээдийн тулалдааны үед сүйдсэн газар орон, сүм хийд, зарим түүхэн үйл явц зэрэг нь түүхэн шаргал хуудасны жин нэмж буй явдалаас; **гуравт**-нэг хүчин нь тулга тойрсон зэвсэгт мөргөлдөөн-тулалдааны явцад цэрэг зэвсгийн хүч нь ихэд тарамдсан, хоёр тулгарах үед дайны бэлтгэл бүрэн хангагдаагүй байсан; нөгөө хүчин нь улс орны зэвсэгт хүчин нь огт доройтоогүй томоохон тулалдаанд орж, цэрэг зэвсгийн хүчээ шалгаад удсан учраас тулгарч болох аюулаас урьдчилан сэргийлэн дахин шалгаж үзэх стратегийн нөхцөл бүрдсэн учраас урьдаар бэлдгэгдсэн цэрэг ангийг тулалдаанд оруулсанаар асуудлыг хүчээр шийдэх сэтгэл зүйн бэлтгэл хурцаар нөлөөлсөн гэсэн саналыг дэвшүүлж байна.

Түшээт хан Чахундорж, Засагт хан Цэнгүм, Өндөр гэгээн, Галдан бошгот хаан нарын биес тэргүүлэн оролцсон Халхын баруун зүүн гараас үүсвэрлэсэн Халх, Ойрадын дайныг 3 бүлэгт хувааж үзэж болмоор байна. Үүнд:

Үүсвэрийн үе . Засагт ханы ширээний тэмцэл эхэлснээс Хүрэн бэлчирийн чуулган хүртэл /1662-1686 оны VIII сар/

Идэвхижлийн үе . Хүрэн бэлчирийн чуулганаас Долон нуурын чуулган хүртэл / 1686 оны IX сар-1690 он/

Төгсгөл ба Ойрад манжийн үе . Долон нуурын чуулганаас

Галдан хаан ганцаардаж эхэлсэн үе /1690- 1697 он /

Ойрадын хан Галдан Халх руу цөмрөн орж, хүчит дөрвөн туурай хөрст дэлхийг тогтоон ядан хурц илдний ааг эрхи зүүсэн лам эрдэнэ титэмлэсэн бурхны толгойг үл ялгахын зэрэгцээ хар хортой зүрх нь хөх тэнгэрийн хүчтэн хүрхрэн луус мэт хүчтэйгээр цохилон байсныг судар бичиг лугаа шүүн үзэхүл :

- Түшээт хан Чахундоржийн өвөг Эрээхэй мэргэний гэргий болон хошуудын Очирт сэцэн ханы гэргий Дорждавдан бас эгч дүү хоёр билээ. Дахивал, Очирт сэцэн ханы омбол Лувсангомборавдан Чахундоржийн охиныг хатнаар залжээ . 1676 онд Галдан бошгот хаан Очирт сэцэн ханыг довтлох үед Чахундорж цэрэг дайчлан өмгөөлөн байлдах гээд завдалгүй буцаж иржээ. Тэр энэ өшөөг бодож , 1677 онд доорхи Сарандаш гэгчээр 300 цэрэг дайчлуулан, Галдан бошготын зүг зарсан элчийг булаалгасан .

- Өндөр гэгээн, Галдан бошгот хоёулаа өндөр боловсролтой хутагт хувилгаад Лхаст олон жил ном үзэж сургууль дүүргэсэн атлаа бурхны ариун дагшин сүм хийдийг түймэрдсэн явдлыг яавч зөвхөн улс үндэстнийхээ төлөө Манжийн дарангуйллыг эсэргүүцсэн тэмцэгч хэмээн өнгөн талыг барьж үзсэнийг анхааран үзэх хэрэгтэй .

Түшээт хан Чахундорж, Жибзундамба хутагт хийгээд халхын ноёдод хоёр л зам байсан . *Нэг нь* хар хятадаас тусламж гуйх, *хоёрт нь* манжийн хаанаас тусламж эрэх. Түшээт хан Чахундорж, Жибзундамба хутагт болон халхын бусад ноёд орон зай, цаг хугацааны шаардлагаар сүүлийн замаар явсан. 1691 оны V сард болсон Долон нуурын чуулганаар Манжийн эзэн хаан халх Монголыг албан ёсоор хүлээн авснаа зарлаад олон ноёд, ван, тайж нарт хэргэм олгосноос гадна Түшээт хан Чахундорж, Жибзундамба хутагт Засагт ханы хүү Цэвээнжав сэцэн нарт мянган лан мөнгө, мөнгөн сав, магнаг торго, бүс, бүрх малгай зэргийг шагнав .

XVII зууны үед Ар, Өвөр, Баруун хэсэгт хуваагдан нэрлэгдэж байсан бүх Монголчуудын ихэнх хэсэг нь болох өвөр Монгол, Халхын хант улс Манжийн нөлөөнд орсноор Монгол улс төрийн голомт нь Зүүн гарын хаант улсын мэдэлд очсноор 70 шахам жил тогтож байгаад 1758 онд итгэлийг эвдэн журмыг тэрслэн эв зөийг сарниулан, Манжийн хааны хүчин чадал хүчин мөхөсдөн эзлэгдсэн. Иймийн тул бүх Монголыг 1691 оноос эхлүүлэн 1911 он хүртэл 221 жил Манжийн нөлөөнд автсан хэмээн үзэмгүй байна. Харин Монгол Улс төрийн

голомт Зүүн гарын хаант улсад хадгалагдаж байгаад 1758 онд эзлэгдсэн үеэс эхлэн 1911 он хүртэл 153 жил бүх монголчууд Манжийн нөлөөнд орсон хэмээн үзэх нь зөв юм. Энэ асуудлыг магадлан сайн судалж, түүхэн утга учрын ороог тайлах хэрэгтэй болой.

Abstract:

Among the statesmen of the 16th century, the century in Mongolian history full of controversial and complicated events, one of the prominent figures was Chakhundorj Gombodorj, the Tusheet Khan of Khalkh.

The Khan Chakhundorj was the direct descendant of Chinggis Khaan in the 21st line, and has united the Khalkh Mongols in a fierce struggle against the emerging aggressive power of the Manchu Qing Empire, leading the military campaign occasionally escalating into a firearm battle.

As a prince of the royal house, Chakhundorj carried the military and religious policies directed to confront the Manchu conquest. In this endeavor he was not alone in his family; his father Gombodorj, his brother Sedshir Beile (viscount) and another brother, Zanabazar, the Undur Gegeen (literally, the Lofty Radiance the Supreme Priest of Khalkh Mongolia) – all fought hard for preserving the Mongolian independence.

The conflict between the Chakhundorj, the Tusheet Khan and Galdan, the Boshgot Khan of the Oirats severely affected the cause of the Mongolian independence and the destiny of the Mongols. Thus, it had become a historical lesson for all Mongolians to understand the importance of unity in times of external challenge.

ЗҮҮЛТ ТАЙЛБАР

1. Түшээт хан аймгийн олон ноёдын уг эх. УТНС / гар бичмэл /
2. Түшээт хан аймгийн олон ноёдын уг эх түүх энэ болой. УТНС / гар бичмэл /
3. Өөлдийн ноёдын уг эх түүх УТНС / гар бичмэл /
4. Мөн тэнд.
5. БНМАУ-ын түүх / дэд дэвтэр / УБ., 1968. Т.80-98.
6. Энх-Амгалан хааны бодлогын бичиг / тавдугаар дэвтэр /
7. Гонгор Д. Халх товчоон / тэргүүн дэвтэр / УБ., 1970. Т.239-255
8. Дашбадрах.Д. Монгол,Түвэдийн улс төр, шашны харилцаа / ХҮП-ХҮШ зуун / УБ., 1998. Т.38
9. Нацагдорж.Ш. Халхын түүх УБ., 1963. Т.54.